



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 15-р цэцэрлэг

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/28/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь төрийн аудитын газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Д.Мягмарсүрэн

Утас: 99030170 Цахим хаяг: www.dalaivanaudit.mn



Товчилсон үгийн жагсаалт


УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3.Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт	17
Залруулсан алдаа	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Төлбөрийн акт, албан шаардлага	18
Аудитын зөвлөмж	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4. Менежментийн захидал	18

1.Төрийн аудитын санал, дүгнэлт

 <p>ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Урт булаг баг, Хөндлөржийн гудамж, Утас/Факс: 70359826 Цахим шуудан: orkhon@audit.gov.mn</p> <p>2021.08.25 № 37</p> <p>талай _____ -ны № _____ -т</p>	<p>ОРХОН АЙМГИЙН 15-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Л.ГЭЛЭГМАА ТАНАА</p>
Аудитын санал дүгнэлт	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	
<p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.</p>	

D:\vny doc \atbanbichla\ 2021-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	105,607,426.58	92,002,466.84
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	51,258.00	51,258.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	51,258.00	51,258.00
3121	Төгрөг	51,258.00	51,258.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	51,258.00	51,258.00
35	БАРАА МАТЕРИАЛ	105,556,168.58	91,951,208.84
351	Түүхий эд материал	98,647,488.58	84,728,608.84
35110	Тусгай зориулалттай материал	98,647,488.58	84,728,608.84
354	Хангамжийн материал	6,908,680.00	7,222,600.00
35420	Аж ахуйн материал	6,067,800.00	4,655,100.00
35460	Хүнсний материал	840,880.00	2,567,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,958,510,139.29	1,942,318,832.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,958,510,139.29	1,942,318,832.85
392	Биет хөрөнгө	1,530,390,139.33	1,514,308,832.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,525,671,269.03	1,568,266,950.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(40,980,291.31)	(95,385,348.58)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,894,963.15	45,343,463.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(13,242,102.17)	(20,109,399.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,802,719.32	57,082,719.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,756,418.69)	(40,889,551.94)
393	Биет бус хөрөнгө	428,119,999.96	428,009,999.92
39301	Програм хангамж	875,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(435,000.04)	(220,000.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	427,680,000.00	427,680,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,064,117,565.87	2,034,321,299.69
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,064,117,565.87	2,034,321,299.69
51	Засгийн газрын хувь оролцоо	2,064,117,565.87	2,034,321,299.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,131,055,744.00	1,131,055,744.00
51101	Өмч: - төрийн	703,375,744.00	703,375,744.00
512	Хуримтлагдсан үр дүн	(47,153,384.62)	(76,949,650.80)
51210	Өмнөх үеийн үр дүн	(47,153,384.62)	(47,153,384.62)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	980,215,206.49	980,215,206.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,064,117,565.87	2,034,321,299.69

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	868,916,861.00	731,553,481.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	228,131,561.00	59,115,081.00
120	Нийтлэг татварын бус орлого	228,131,561.00	59,115,081.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	228,131,561.00	59,115,081.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	228,131,561.00	59,115,081.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	640,785,300.00	672,438,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	521,676,400.00	615,807,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	521,676,400.00	615,807,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,409,700.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,075,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,126,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	208,700.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,699,200.00	56,630,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,699,200.00	56,630,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	700,364,492.45	761,349,747.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	700,364,492.45	761,349,747.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	699,554,192.45	738,577,778.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	424,497,069.00	487,898,200.00
210101	Үндсэн цалин	386,652,697.00	357,678,920.00
210104	Урамшуулал	37,844,372.00	36,806,482.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,770,600.00	62,052,594.00
210201	Тэтгэврийн даатгал	36,925,940.00	42,705,117.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,334,479.00	5,010,951.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,435,328.00	3,948,280.00
210204	Ажилгүйдлийн даатгал	824,987.00	944,385.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,249,866.00	9,443,861.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,893,871.00	31,546,467.00



Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210301	Гэрэл, цахилгаан	6,194,255.00	4,177,568.00
210302	Түлш, халаалт	20,121,695.00	17,525,829.00
210303	Цэвэр, бохир ус	15,577,921.00	9,843,070.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,224,170.00	35,102,959.74
210401	Бичиг хэрэг	263,400.00	193,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	281,130.00	335,200.00
210404	Ном, хэвлэл	1,860,000.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	179,270.00	7,198,580.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,226,000.00	13,196,900.00
210408	Бараа материал акталсны зардал	3,414,370.00	14,128,879.74
2105	Нормативт зардал	102,713,960.00	47,335,670.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55,600.00	206,200.00
210502	Хоол, хүнс	99,265,360.00	46,061,870.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,393,000.00	1,067,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,925,160.00	3,084,200.00
210604	Урсгал засвар	2,925,160.00	3,084,200.00
2107	Томилолт, зочны зардал	46,000.00	-
210702	Дотоод албан томилолт	46,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	567,500.00	1,265,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	389,500.00	257,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	178,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,915,862.45	70,292,187.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	459,600.00	609,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,488,200.00	4,167,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,968,062.45	65,515,487.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	810,300.00	22,771,969.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	810,000.00	180,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	810,000.00	180,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	200.00	22,000,133.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	200.00	22,000,133.00

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	100.00	591,836.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	100.00	591,836.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	168,552,368.55	(29,796,266.18)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,277,362.79	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,277,362.79	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4,277,362.79)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	164,275,005.76	(29,796,266.18)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	645,149,237.00	692,934,992.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	645,149,237.00	692,934,992.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	521,676,400.00	615,807,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	521,676,400.00	615,807,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,409,700.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,075,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,126,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	208,700.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,699,200.00	56,630,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,699,200.00	56,630,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,363,937.00	20,496,592.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,363,937.00	20,496,592.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	643,699,237.00	692,934,992.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	643,699,237.00	692,934,992.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	638,525,000.00	649,666,431.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	424,497,069.00	487,898,200.00
210101	Үндсэн цалин	386,652,697.00	357,678,920.00
210104	Урамшуулал	37,844,372.00	36,806,482.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,770,600.00	62,052,594.00
210201	Тэтгэврийн даатгал	36,925,940.00	42,705,117.00



Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	4,334,479.00	5,010,951.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,435,328.00	3,948,280.00
210204	Ажилгүйдлийн даатгал	824,987.00	944,385.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,249,866.00	9,443,861.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,893,871.00	31,546,467.00
210301	Гэрэл, цахилгаан	6,194,255.00	4,177,568.00
210302	Түлш, халаалт	20,121,695.00	17,525,829.00
210303	Цэвэр, бохир ус	15,577,921.00	9,843,070.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,556,100.00	10,746,880.00
210401	Бичиг хэрэг	216,900.00	193,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	281,130.00	335,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	179,270.00	7,953,080.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	878,800.00	2,215,200.00
2105	Нормативт зардал	106,862,700.00	49,062,290.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55,600.00	206,200.00
210502	Хоол, хүнс	98,954,100.00	47,788,490.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,853,000.00	1,067,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,185,160.00	3,084,200.00
210602	Тавилга	260,000.00	-
210604	Урсгал засвар	2,925,160.00	3,084,200.00
2107	Томилолт, зочны зардал	46,000.00	-
210702	Дотоод албан томилолт	46,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	567,500.00	1,265,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	389,500.00	257,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	178,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,146,000.00	4,010,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	459,600.00	609,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,686,400.00	3,400,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,174,237.00	43,268,561.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,173,937.00	20,676,592.00



Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,363,937.00	20,496,592.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	810,000.00	180,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	200.00	22,000,133.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	200.00	22,000,133.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	100.00	591,836.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	100.00	591,836.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,450,000.00	=
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,450,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,450,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,450,000.00	-
223001	Бусад хөрөнгө	1,450,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,450,000.00)	=
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	51,258.00	51,258.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	51,258.00	51,258.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,131,055,744.00	980,215,206.49	(217,987,947.50)	1,893,283,002.99
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	6,559,557.12	6,559,557.12
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,131,055,744.00	980,215,206.49	(211,428,390.38)	1,899,842,560.11
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	164,275,005.76	164,275,005.76



Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,131,055,744.00	980,215,206.49	(47,153,384.62)	2,064,117,565.87
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,131,055,744.00	980,215,206.49	(47,153,384.62)	2,064,117,565.87
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,131,055,744.00	980,215,206.49	(47,153,384.62)	2,064,117,565.87
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(29,796,266.18)	(29,796,266.18)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,131,055,744.00	980,215,206.49	(76,949,650.80)	2,034,321,299.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	672438400.00	649846431.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	672438400.00	649846431.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	672238400.00	649666431.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	487898200.00	487898200.00
210101	Үндсэн цалин	311203600.00	357678920.00
210102	Нэмэгдэл	136727300.00	92293598.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3360000.00	1119200.00
210104	Урамшуулал	36607300.00	36806482.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62052600.00	62052594.00

Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	42642600.00	42705117.00
210202	Тэтгэмжийн даатгал	4852500.00	5010951.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3882000.00	3948280.00
210204	Ажилгүйдлийн даатгал	970500.00	944385.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9705000.00	9443861.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53546600.00	31546467.00
210301	Гэрэл, цахилгаан	12765600.00	4177568.00
210302	Түлш, халаалт	29582700.00	17525829.00
210303	Цэвэр, бохир ус	11198300.00	9843070.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10817900.00	10746880.00
210401	Бичиг хэрэг	193400.00	193400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	335,200.00	335,200.00
210404	Ном, хэвлэл	121,000.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,953,100.00	7,953,080.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,215,200.00	2,215,200.00
2105	Нормативт зардал	49,062,300.00	49,062,290.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	206,200.00	206,200.00
210502	Хоол, хүнс	47,788,500.00	47,788,490.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,067,600.00	1,067,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,084,200.00	3,084,200.00
210604	Урсгал засвар	3,084,200.00	3,084,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,565,400.00	1,265,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	257,500.00	257,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,307,900.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,013,500.00	4,010,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	612,800.00	609,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,400,700.00	3,400,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,000.00	180,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	180,000.00



Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	180,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	672,438,400.00	649,846,431.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	615,807,600.00	615,215,764.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	615,807,600.00	615,215,764.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	56,630,800.00	34,630,667.00
132001	Орон нутгийн төсвөөс	56,630,800.00	34,630,667.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Л.Гэлэгмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК Орхон аймаг дахь салбарын захирал Д.Мягмарсүрэн, аудитор Б.Пүрэвсүрэн, туслах аудитор Б.Дулмаа /Орхон аймгийн төрийн аудитын газрын захиалгаар/ хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газар / Орхон аймаг дахь Төрийн аудитын газар/-т 2021 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрхэм зорилго:

Орхон аймгийн 15-р цэцэрлэг нь үндэсний өв, уламжлалаа дээдлэн, хүүхдийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих хөгжлийг дэмжин, суралцагч байгууллага болох гэсэн зорилгын хүрээнд ажиллаж байна гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2020 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд гарсан онцлог өөрчлөлт, шинэчлэлт байхгүй.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймгийн 15-р цэцэрлэг нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Орхон аймаг дахь Санхүү хяналт, аудитын алба 2020 онд Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 373,481.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 3,734.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 731,553.5 мянган төгрөгийн 1 хувиар буюу 7,315.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,796.3 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	51.3	51.3	
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	105,556.2	91,951.2	(13,605.0)
Үндсэн хөрөнгө	1,958,510.1	1,942,318.8	(16,191.3)
Нийт хөрөнгө	2,064,117.5	2,034,321.3	(29,796.2)
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,064,117.5	2,034,321.3	(29,796.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,064,117.5	2,034,321.3	(29,796.2)

Тайланд оны эцсээр авлага, өр төлбөргүй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 91,951.2 мянган төгрөг болж 13,605.0 мянган төгрөгөөр буурсан нь эрхлэгчийн 2020 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/14 тоот тушаалыг үндэслэн 10 нэр төрлийн 14,128.9 мянган төгрөгийн бараа материал акталсантай холбоотой. Бараа материалын дансны үлдэгдэлд ашигладаггүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,942,318.8 мянган төгрөг болж 16,191.3 мянган төгрөгөөр буурсан нь ашиглалтын хугацаа дууссан 325.0 мянган төгрөгийн хуучин программ хангамжийг Орхон аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/754 тоот захирамжийн дагуу акталж данснаас хассан болон тайлант хугацааны хуримтлагдсан элэгдлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны 2,034,321.3 мянган төгрөг болж 29,796.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 137,363.4 мянган төгрөгөөр буюу 6 хувиар буурсан бөгөөд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос буурснаас шалтгаалсан байна. Харин төсвийн санхүүжилтийн орлого 94,131.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 49,235.7 мянган төгрөгөөр буюу 7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс 63,401.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 9,190.8 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 38,094.3 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 108,367.7 мянган төгрөгөөр бууруулж 672,438.4 мянган төгрөгөөр баталсан байна. Үндсэн цалин 10,398.8 мянган төгрөгөөр, үр дүнгийн урамшуулал 22,223.7 мянган төгрөгөөр, цэвэр, бохир ус 10,841.7 мянган төгрөгөөр, нормын хувцас, зөөлөн эдлэл 1,533.3 мянган төгрөгөөр, хоол, хүнс 61,936.5 мянган төгрөгөөр өсгөж төлөвлөсөн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 672,438.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 615,807.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 56,630.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 615,215.8 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 34,630.7 төгрөгийн, нийт 649,846.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаандаа 649,846.4 мянган төгрөгийг зарцуулж, 22,592.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн буюу төсвийн хэмнэлт үүссэн нь Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоож, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдсантай холбоотой байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 22,000.1 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардал 197.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.



Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй бөгөөд зарцуулалт хийгээгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 1 мэдээллийг буруу оруулсныг залруулснаар хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар 1-12 сарын санхүүжилтийн 672,438.4 мянган төгрөгийн мэдээллийг тогтмол мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3		3		3		100
Нийт дүн	3		3		3		100

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,497.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,578.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага тогтоож, 4,918.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой залруулга үүсээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 4,578.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,578.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага тогтоолоо. Үүнд

Төлбөрийн акт, албан шаардлага

Нийт албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхцуулан цалингийн зардлын хэмнэлтээс албан хаагч бүрд 151.0 мянган төгрөг, нийт 4,578.7 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн албаны тухай хуулийн 51.2-д “Энэ хуулийн 51.1.1-д заасан шагнал олгох, 51.1.3-т заасан шагналд тодорхойлох болон 51.1.4-т заасан мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар, ... батална”, 57.8-д “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.4, 4.5 дахь заалт, 2018 оны 382-р тогтоолын 2-д “Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 4,918.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлангийн жилд анхаарал татахуйц чухал асуудал байхгүй гэж үзэж байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Бараа материалын орлогодож зарлагадсан зарим гүйлгээний анхан шатны баримтын гарын үсэг дутуу, шаардах хуудас, орлого, зарлагын баримт тамга тэмдгээр баталгаажаагүй, бараа материалыг шаардах хуудасгүй зарлага бүртгэсэн, цахим баримтгүй шаардлага хангахгүй баримтаар гүйлгээг бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчиж байна.
- 1.2. Эрсдэл: Төсвийн үрэлгэн зардал өсөх, дотоод хяналт алдагдах.

- 1.3. Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангасан ажил гүйлгээ бүртгэж тайлагнан, дотоод хяналтыг сайжруулах.
- 1.4. Байгууллагаас өгсөн харуу тайлбар: Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

Шилэн данстай холбоотой асуудал

- 2.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 1 мэдээллийг буруу оруулсныг залруулснаар хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй байна. Хугацаа хоцроож байршуулсан 1 мэдээлэл, иж бүрэн бус мэдээлсэн 1 мэдээлэл байх ба 2 удаагийн 4,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийн орлогыг дутуу мэдээлснийг залруулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2-т “Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
- 2.2 Эрсдэл: Мэдээлэл хэрэглэгчийн буруу мэдээллээр хангах, төсвийн ил тод байдал хангагдахгүй байх.
- 2.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хууль, журмын дагуу мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, дотоод хяналт хэрэгжүүлэх.
- 2.4 Байгууллагаас өгсөн харуу тайлбар: Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТЫН ТАЙЛАНГ

Бэлтгэсэн:	Аудитор		Б.Пүрэвсүрэн	Огноо 2021.02.16
Анхан шатанд хянасан:	Аудитын менежер		Б.Эрдэнэ	Огноо 2021.02.16
Хоёр дахь шатанд хянасан:	Дарга, тэргүүлэх аудитор		Ц.Нармандах	Огноо

